ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН**

---

# Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ӨВА-2022/120/НА-СТА-ТШЗ**

---


Цахим хуудас: www.audit.mn

Өвөрхангай аймаг,
Арвайхээр сум

2022 он

Тэргүүлэх аудитор: О.Батжаргал

Утас: 70323253 Цахим хаяг: Batjargalo@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Гансүх

Утас: 70323833 Цахим хаяг: gansukh.audit@gmail.com

Ахлах аудитор: П.Хорлоосүрэн

Утас: 70323108 Цахим хаяг: Khorloosuren.audit@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.Аудитын санал дүгнэлт.....2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....6
2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....11
3.Аудитын тайлан.....11
3.1 Ерөнхий зүйл.....11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....12
3.4 Материаллаг байдал.....12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....**Error! Bookmark not defined.**
3.8 Аудитын гол асуудал.....**Error! Bookmark not defined.**
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....13
3.10 Шилэн дансны мэдээлэл.....**Error! Bookmark not defined.**
3.11. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....**Error! Bookmark not defined.**
3.12 Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....**Error! Bookmark not defined.**
4. Аудитын илрүүлэлт.....**Error! Bookmark not defined.**
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....**Error! Bookmark not defined.**

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

1.Аудитын гэрчилгээ

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Б.ЦЭДМАА ТАНАА

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,
Утас/Факс: (976) 7032 3253,
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

2022.02.08 № 104

танай __________-ны №__________-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| данс | Үзүүлэлт | ҮЛДЭГДЭЛ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 9,421,570.00 | 55,941,098.20 |
| 2 | МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ | 0.00 | 68,316.00 |
| 8 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 0.00 | 68,316.00 |
| 9 | Төгрөг | 0.00 | 68,316.00 |
| 12 | Арилжааны банкин дахь харилцах | - | 68,316.00 |
| 27 | АВЛАГА | 128,026.00 | 532,066.00 |
| 34 | Бусад авлага | 128,026.00 | 532,066.00 |
| 35 | Байгууллагаас авах авлага | 128,026.00 | 532,066.00 |
| 60 | БАРАА МАТЕРИАЛ | 9,293,544.00 | 55,340,716.20 |
| 61 | Түүхий эд материал | 9,293,544.00 | 16,243,416.20 |
| 62 | Тусгай зориулалттай материал | 9,293,544.00 | 16,243,416.20 |
| 66 | Хангамжийн материал | - | 39,097,300.00 |
| 67 | Бичиг хэргийн материал | - | 2,688,300.00 |
| 68 | Аж ахуйн материал | - | 7,990,000.00 |
| 73 | Бусад хангамжийн материал | - | 28,419,000.00 |
| 86 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 56,153,766.05 | 224,677,638.74 |
| 106 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 56,153,766.05 | 224,677,638.74 |
| 108 | Биет хөрөнгө | 56,153,766.05 | 219,026,638.74 |
| 111 | Авто тээврийн хэрэгсэл | 29,480,000.00 | 29,480,000.00 |
| 112 | Хуримтлагдсан элэгдэл | (921,249.99) | (4,606,249.95) |
| 113 | Машин, тоног төхөөрөмж | 186,754,390.61 | 365,308,120.58 |
| 114 | Хуримтлагдсан элэгдэл | (165,006,700.87) | (180,055,656.95) |
| 115 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 33,667,690.00 | 40,788,690.00 |
| 116 | Хуримтлагдсан элэгдэл | (27,820,363.70) | (31,888,264.94) |
| 126 | Биет бус хөрөнгө | - | 5,651,000.00 |
| 127 | Програм хангамж | 5,690,450.00 | 7,021,450.00 |
| 128 | Хасагдуулга | (5,690,450.00) | (5,690,450.00) |
| 129 | Бусад биет бус хөрөнгө | - | 4,320,000.00 |
| 137 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 65,575,336.05 | 280,618,736.94 |
| 138 | НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН | 0.00 | 68,316.00 |
| 139 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 0.00 | 68,316.00 |
| 177 | Урьдчилж орсон орлого | - | 68,316.00 |
| 178 | Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв | - | 68,316.00 |
| 214 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | 65,575,336.05 | 280,550,420.94 |
| 215 | Засгийн газрын хувь оролцоо | 65,575,336.05 | 280,550,420.94 |
| 223 | Хуримтлагдсан үр дүн | 65,575,336.05 | 280,550,420.94 |
| 224 | Өмнөх үеийн үр дүн | 65,575,336.05 | 65,447,310.05 |
| 225 | Тайлант үеийн үр дүн | - | 215,103,110.89 |
| 231 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | 65,575,336.05 | 280,618,736.94 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| данс | ГҮЙЛГЭЭ | ГҮЙЦЭТГЭЛ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 830,303,875.06 | 894,584,280.92 |
| 76 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 59,405,175.06 | 250,395,680.92 |
| 77 | Нийтлэг татварын бус орлого | 59,405,175.06 | 250,395,680.92 |
| 81 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 59,405,175.06 | 250,395,680.92 |
| 86 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 59,405,175.06 | 4,320,000.00 |
| 90 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | - | 179,454,050.92 |
| 91 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | - | 66,621,630.00 |
| 111 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 770,898,700.00 | 644,188,600.00 |
| 112 | Улсын төвлөрсөн төсвөөс | 580,917,700.00 | 539,893,500.00 |
| 113 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 580,917,700.00 | 539,893,500.00 |
| 122 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 189,981,000.00 | 104,295,100.00 |
| 125 | ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс | 9,000,000.00 | 7,500,000.00 |
| 126 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи | 180,981,000.00 | 96,795,100.00 |
| 147 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II) | 812,610,685.51 | 678,812,849.08 |
| 148 | УРСГАЛ ЗАРДАЛ | 812,610,685.51 | 678,812,849.08 |
| 149 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 806,966,921.46 | 675,973,531.08 |
| 150 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 472,994,095.00 | 441,643,614.00 |
| 151 | Цалин | 391,902,335.00 | 377,243,700.00 |
| 152 | Нэмэгдэл цалин | 70,887,060.00 | 54,785,914.00 |
| 153 | Унаа хоолны хөнгөлөлт | 10,204,700.00 | 9,614,000.00 |
| 157 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 59,961,533.95 | 59,085,838.00 |
| 158 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 40,379,494.35 | 42,039,657.48 |
| 159 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 4,762,418.38 | 4,045,680.13 |
| 160 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 4,594,013.72 | 3,095,432.27 |
| 161 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 929,593.52 | 1,292,139.51 |
| 162 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 9,296,013.98 | 8,612,928.61 |
| 164 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 21,072,894.00 | 19,689,485.00 |
| 165 | Гэрэл цахилгааны зардал | 4,580,630.00 | 3,117,821.00 |
| 166 | Түлш, халаалтын зардал | 14,598,584.00 | 14,926,944.00 |
| 167 | Цэвэр, бохир усны зардал | 1,893,680.00 | 1,644,720.00 |
| 170 | Хангамж, бараа материалын зардал | 24,625,969.55 | 19,504,386.50 |
| 171 | Бичиг хэргийн материал | 12,401,008.00 | 6,861,400.00 |
| 172 | Тээвэр, шатахууны зардал | 2,303,500.00 | 2,093,100.00 |
| 173 | Шуудан холбоо интернетийн төлбөр | 4,073,915.00 | 2,070,159.00 |
| 175 | Хог хаягдал устгах, цэвэрлэх | 31,200.00 | 42,500.00 |
| 176 | Бага үнэ түргэн элэгдэл зүйлс | 5,816,346.55 | 7,045,100.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 178 | Бараа материал актасны зардал | - | 1,392,127.50 |
| 185 | Эд хогшил, урсгал засварын зардал | 4,156,228.00 | 991,000.00 |
| 186 | Багаж хэрэгсэл | 92,000.00 | 182,000.00 |
| 188 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | 864,028.00 | 500,000.00 |
| 189 | Урсгал засвар | 3,200,200.00 | 309,000.00 |
| 190 | Томилолт, зочны зардал | 414,000.00 | 240,000.00 |
| 192 | Дотоод томилолтын зардал | 414,000.00 | 240,000.00 |
| 194 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 29,450,842.70 | 14,227,750.30 |
| 195 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 7,760,960.00 | 722,130.00 |
| 196 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 300,000.00 | - |
| 197 | Даатгалын үйлчилгээний төлбөр | 119,340.00 | 119,450.00 |
| 198 | Тээврийн хэрэгслийн татвар | 78,500.00 | 64,340.00 |
| 199 | Тээврийн хэрэсглийн оношилгоо | - | 22,000.00 |
| 203 | Улсын мэдээллийн маягтын зардал | 21,192,042.70 | 13,299,830.30 |
| 209 | Бараа үйлчилгээний бусад зардал | 194,291,358.26 | 120,591,457.28 |
| 210 | Бараа үйлчилгээний бусад зардал | 180,981,000.00 | 96,795,100.00 |
| 211 | Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал | 550,000.00 | 994,500.00 |
| 212 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 12,760,358.26 | 22,801,857.28 |
| 224 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 5,643,764.05 | 2,839,318.00 |
| 228 | Бусад урсгал шилжүүлэг | 465,000.00 | 374,000.00 |
| 236 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 465,000.00 | 374,000.00 |
| 237 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 5,178,764.05 | 2,465,318.00 |
| 240 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5,178,764.05 | 2,465,318.00 |
| 268 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II) | 17,693,189.55 | 215,771,431.84 |
| 276 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V) | - | 668,320.95 |
| 277 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 668,320.95 |
| 287 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V) | - | (668,320.95) |
| 288 | НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI) | 17,693,189.55 | 215,103,110.89 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| ДАНС | ГҮЙЛГЭЭ | ГҮЙЦЭТГЭЛ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 1,018,582,926.08 | 940,293,720.02 |
| 77 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 247,684,226.08 | 296,105,120.02 |
| 78 | Нийтлэг татварын бус орлого | 247,684,226.08 | 296,105,120.02 |
| 82 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 247,684,226.08 | 296,105,120.02 |
| 83 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 247,684,226.08 | 296,105,120.02 |
| 110 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 770,898,700.00 | 644,188,600.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 111 | Улсын төвлөрсөн төсвөөс | 580,917,700.00 | 539,893,500.00 |
| 112 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 580,917,700.00 | 539,893,500.00 |
| 121 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 189,981,000.00 | 104,295,100.00 |
| 124 | ЗГНХ, ЗДНХөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс | 9,000,000.00 | 7,500,000.00 |
| 125 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи | 180,981,000.00 | 96,795,100.00 |
| 147 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II) | 1,017,874,876.08 | 932,005,404.02 |
| 148 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,017,874,876.08 | 932,005,404.02 |
| 149 | БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 764,546,885.95 | 633,129,282.00 |
| 150 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 460,081,900.00 | 419,825,010.00 |
| 151 | Үндсэн цалин | 379,419,861.00 | 355,566,559.00 |
| 152 | Нэмэгдэл | 70,293,439.00 | 54,644,451.00 |
| 153 | Унаа хоолны хөнгөлөлт | 10,368,600.00 | 9,614,000.00 |
| 157 | Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл | 72,873,728.95 | 80,904,442.00 |
| 158 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 55,589,140.88 | 64,412,542.00 |
| 159 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 3,868,151.97 | 4,157,600.00 |
| 160 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 4,190,404.62 | 3,187,600.00 |
| 161 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 839,139.22 | 831,500.00 |
| 162 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 8,386,892.26 | 8,315,200.00 |
| 164 | Байр ашиглалтай  холбоотой тогтмол зардал | 21,072,894.00 | 20,221,551.00 |
| 165 | Гэрэл цахилгааны зардал | 4,580,630.00 | 3,117,821.00 |
| 166 | Түлш, халаалтын зардал | 14,598,584.00 | 15,459,010.00 |
| 167 | Цэвэр, бохир усны зардал | 1,893,680.00 | 1,644,720.00 |
| 170 | Хангамж, бараа материалын зардал | 16,158,335.00 | 12,229,759.00 |
| 171 | Бичиг хэрэг | 7,226,220.00 | 6,248,900.00 |
| 172 | Тээвэр, шатахуун | 2,303,500.00 | 2,093,100.00 |
| 173 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,073,915.00 | 2,070,159.00 |
| 175 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 31,200.00 | 42,500.00 |
| 176 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,523,500.00 | 1,775,100.00 |
| 185 | Эд хогшил, урсгал засварын зардал | 4,156,228.00 | 991,000.00 |
| 186 | Багаж техник хэрэгсэл | 92,000.00 | 182,000.00 |
| 188 | Хөдөлмөр хамгааллийн хэрэгсэл | 864,028.00 | 500,000.00 |
| 189 | Урсгал засвар | 3,200,200.00 | 309,000.00 |
| 190 | Томилолт, зочны зардал | 414,000.00 | 240,000.00 |
| 192 | Дотоод албан томилолт | 414,000.00 | 240,000.00 |
| 194 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 8,258,800.00 | 927,920.00 |
| 195 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 7,760,960.00 | 722,130.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 196 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 300,000.00 | - |
| 197 | Даатгалын үйлчилгээ | 119,340.00 | 119,450.00 |
| 198 | Тээврийн хэрэгслийн татвар | 78,500.00 | 64,340.00 |
| 199 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | - | 22,000.00 |
| 208 | Бараа үйлчилгээний бусад зардал | 181,531,000.00 | 97,789,600.00 |
| 209 | Бараа үйлчилгээний бусад зардал | 180,981,000.00 | 96,795,100.00 |
| 210 | Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх | 550,000.00 | 994,500.00 |
| 221 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 253,327,990.13 | 298,876,122.02 |
| 225 | Бусад урсгал шилжүүлэг | 465,000.00 | 374,000.00 |
| 233 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 465,000.00 | 374,000.00 |
| 234 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 252,862,990.13 | 298,502,122.02 |
| 237 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5,178,764.05 | 2,465,318.00 |
| 238 | Улсын төсөвт орлогод төвлөрүүлэх шилжүүлэг | 247,684,226.08 | 296,036,804.02 |
| 250 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 708,050.00 | 8,288,316.00 |
| 251 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 261 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 708,050.00 | 8,220,000.00 |
| 262 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 708,050.00 | 8,220,000.00 |
| 263 | Дотоод эх үүсвэрээр | 708,050.00 | 8,220,000.00 |
| 275 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 708,050.00 | 8,220,000.00 |
| 278 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | (708,050.00) | (8,220,000.00) |
| 303 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 0.00 | 68,316.00 |
| 304 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 0.00 |
| 305 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 68,316.00 |

## 2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

| | ҮЗҮҮЛЭЛТ | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 0 | ДАНС | 511 | 51300 | 51210+51220 | |
| 2 | 2020 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл | 0.00 | 0.00 | 47882146.50 | 47882146.50 |
| 3 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 4 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 0.00 | 0.00 | 47882146.50 | 47882146.50 |
| 5 | Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн | 0 | 0.00 | 0 | 0.00 |
| 6 | Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз | 0 | 0 | 0 | 0.00 |
| 7 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз | 0 | 0 | 0 | 0.00 |
| 8 | Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | 0.00 | 0 | 17693189.55 | 17693189.55 |
| 9 | 2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 0.00 | 0.00 | 65575336.05 | 65575336.05 |
| 10 | 2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 0.00 | 0.00 | 65575336.05 | 65575336.05 |
| 11 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | -128026.00 | -128026.00 |
| 12 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 0.00 | 0.00 | 65447310.05 | 65447310.05 |
| 13 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0 | 0.00 | 0 | 0.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 14 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 0.00 | 0 | 0 | 0.00 |
| 15 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз | 0 | 0 | 0 | 0.00 |
| 16 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 0 | 0 | 0 | 0.00 |
| 17 | Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | 0 | 0 | 215103110.89 | 214571044.89 |
| 18 | 2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 0.00 | 0.00 | 280550420.94 | 280550420.95 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| АН | ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Дүн | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөн | - | - | - | - | - | - |
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭ | 580,917,700.00 | 575,738,935.95 | 540,243,100.00 | 537,428,182.00 | 2,814,918.00 | 99.48 |
| 3 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 580,917,700.00 | 575,738,935.95 | 540,243,100.00 | 537,428,182.00 | 2,814,918.00 | 99.48 |
| 4 | Бараа, үйлчилгээний зардал | 580,450,300.00 | 575,273,935.95 | 539,868,700.00 | 537,054,182.00 | 2,814,518.00 | 99.48 |
| 5 | Цалин хөлс болон нэмэгдэл ура | 460,081,900.00 | 460,081,900.00 | 419,958,600.00 | 419,825,010.00 | 133,590.00 | 99.97 |
| 6 | Үндсэн цалин | 384,807,800.00 | 379,419,861.00 | 344,684,500.00 | 355,566,559.00 | (10,882,059.00) | 103.16 |
| 7 | Нэмэгдэл | 64,978,100.00 | 70,293,439.00 | 64,978,100.00 | 54,644,451.00 | 10,333,649.00 | 84.10 |
| 8 | Унаа, болон бусад нөхөн олгов | 10,296,000.00 | 10,368,600.00 | 10,296,000.00 | 9,614,000.00 | 682,000.00 | 93.38 |
| 11 | Ажил олгогчоос нийгмийн даат | 75,180,400.00 | 72,873,728.95 | 81,995,900.00 | 80,904,442.00 | 1,091,458.00 | 98.67 |
| 12 | Тэтгэврийн даатгал | 56,856,400.00 | 55,589,140.88 | 65,365,900.00 | 64,412,542.00 | 953,358.00 | 98.54 |
| 13 | Тэтгэмжийн даатгал | 4,581,000.00 | 3,868,151.97 | 4,157,200.00 | 4,157,600.00 | (400.00) | 100.01 |
| 14 | ҮОМШӨ ний даатгал | 3,664,800.00 | 4,190,404.62 | 3,326,100.00 | 3,187,600.00 | 138,500.00 | 95.84 |
| 15 | Ажилгүйдлийн даатгал | 916,200.00 | 839,139.22 | 831,500.00 | 831,500.00 | - | 100.00 |
| 16 | Эрүүл мэндийн даатгал | 9,162,000.00 | 8,386,892.26 | 8,315,200.00 | 8,315,200.00 | - | 100.00 |
| 17 | Байр ашиглалттай холбоотой тө | 23,670,000.00 | 21,072,894.00 | 21,012,000.00 | 20,221,551.00 | 790,449.00 | 96.24 |
| 18 | Гэрэл цахилгаан | 5,268,000.00 | 4,580,630.00 | 4,565,600.00 | 3,117,821.00 | 1,447,779.00 | 68.29 |
| 19 | Түлш, халаалт | 14,934,000.00 | 14,598,584.00 | 13,440,800.00 | 15,459,010.00 | (2,018,210.00) | 115.02 |
| 20 | Цэвэр, бохир ус | 3,468,000.00 | 1,893,680.00 | 3,005,600.00 | 1,644,720.00 | 1,360,880.00 | 54.72 |
| 22 | Хангамж, бараа материалын зар | 16,331,200.00 | 16,158,335.00 | 12,297,400.00 | 12,229,759.00 | 67,641.00 | 99.45 |
| 23 | Бичиг хэрэг | 7,227,100.00 | 7,226,220.00 | 5,202,000.00 | 6,248,900.00 | (1,046,900.00) | 120.12 |
| 24 | Тээвэр (шатахуун) | 2,303,500.00 | 2,303,500.00 | 2,093,100.00 | 2,093,100.00 | - | 100.00 |
| 25 | Шуудан холбоо, интернэтийн т | 4,240,100.00 | 4,073,915.00 | 3,136,500.00 | 2,070,159.00 | 1,066,341.00 | 66.00 |
| 27 | Хог хаягдал зайлуулах, хортон | 37,000.00 | 31,200.00 | 42,500.00 | 42,500.00 | - | 100.00 |
| 28 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж | 2,523,500.00 | 2,523,500.00 | 1,823,300.00 | 1,775,100.00 | 48,200.00 | 97.36 |
| 34 | Эд хогшил худалдан авах | 2,867,500.00 | 2,864,278.00 | 2,085,000.00 | 1,711,000.00 | 374,000.00 | 82.06 |
| 35 | Багаж, техник, хэрэгсэл | 800,500.00 | 800,050.00 | 910,000.00 | 902,000.00 | 8,000.00 | 99.12 |
| 37 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | 866,800.00 | 864,028.00 | 500,000.00 | 500,000.00 | - | 100.00 |
| 38 | Урсгал засвар | 1,200,200.00 | 1,200,200.00 | 675,000.00 | 309,000.00 | 366,000.00 | 45.78 |
| 39 | Томилолт, зочны зардал | 414,000.00 | 414,000.00 | 249,600.00 | 240,000.00 | 9,600.00 | 96.15 |
| 41 | Дотоод албан томилолт | 414,000.00 | 414,000.00 | 249,600.00 | 240,000.00 | 9,600.00 | 96.15 |
| 43 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, ү | 1,352,400.00 | 1,258,800.00 | 1,256,200.00 | 927,920.00 | 328,280.00 | 73.87 |
| 44 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, ү | 761,900.00 | 760,960.00 | 722,200.00 | 722,130.00 | 70.00 | 99.99 |
| 45 | Аудит, баталгаажуулалт зэрэгл | 300,000.00 | 300,000.00 | 224,000.00 | - | 224,000.00 | - |
| 46 | Даатгалын үйлчилгээ | 120,000.00 | 119,340.00 | 120,000.00 | 119,450.00 | 550.00 | 99.54 |
| 47 | Тээврийн хэрэгслийн татвар | 148,500.00 | 78,500.00 | 120,000.00 | 64,340.00 | 55,660.00 | 53.62 |
| 48 | Тээврийн хэрэгслийн оношилго | 22,000.00 | - | 22,000.00 | 22,000.00 | - | 100.00 |
| 50 | Газрын төлбөр | | | 48,000.00 | - | 48,000.00 | - |
| 53 | Бараа үйлчилгээний бусад зард | 552,900.00 | 550,000.00 | 1,014,000.00 | 994,500.00 | 19,500.00 | 98.08 |
| 55 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага | 552,900.00 | 550,000.00 | 1,014,000.00 | 994,500.00 | 19,500.00 | 98.08 |
| 66 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 467,400.00 | 465,000.00 | 374,400.00 | 374,000.00 | 400.00 | 99.89 |
| 70 | Бусад урсгал шилжүүлэг | 467,400.00 | 465,000.00 | 374,400.00 | 374,000.00 | 400.00 | 99.89 |
| 78 | Нэг удаагийн тэтгэмж урамшуу | 467,400.00 | 465,000.00 | 374,400.00 | 374,000.00 | 400.00 | 99.89 |
| 97 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ | 580,917,700.00 | 580,917,700.00 | 539,893,500.00 | 539,893,500.00 | - | 100.00 |
| 98 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮ | 580,917,700.00 | 580,917,700.00 | 539,893,500.00 | 539,893,500.00 | - | 100.00 |
| 99 | Улсын төсвөөс санхүүжих | 580,917,700.00 | 580,917,700.00 | 539,893,500.00 | 539,893,500.00 | - | 100.00 |
| 127 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | - | 0.00 | (0.00) | - |
| 128 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | | - | 68,316.00 | (68,316.00) | - |
| 129 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | | | - | - | - | - |
| 130 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | - | - | - | - | - | - |
| 133 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 41.00 | 41.00 | 41.00 | 41.00 | - | 100.00 |
| 134 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | 1.00 | 1.00 | - | 100.00 |
| 135 | Гүйцэтгэх ажилтан | 33.00 | 33.00 | 33.00 | 33.00 | - | 100.00 |
| 136 | Үйлчлэх ажилтан | 7.00 | 7.00 | 7.00 | 7.00 | - | 100.00 |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Данс | ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Хувь |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөр | - | - | - | - | - |
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭЕ | 189,981,000.00 | 189,981,000.00 | 104,295,100.00 | 104,295,100.00 | 100.00 |
| 3 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 189,981,000.00 | 189,981,000.00 | 104,295,100.00 | 104,295,100.00 | 100.00 |
| 4 | Бараа, үйлчилгээний зардал | 189,981,000.00 | 189,981,000.00 | 104,295,100.00 | 104,295,100.00 | 100.00 |
| 34 | Эд хогшил худалдан авах | 2,000,000.00 | 2,000,000.00 | 6,169,000.00 | 6,169,000.00 | 100.00 |
| | Урсгал засвар | 2,000,000.00 | 2,000,000.00 | | | |
| 35 | Багаж, техник, хэрэгсэл | | | 6,169,000.00 | 6,169,000.00 | 100.00 |
| 43 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил | 7,000,000.00 | 7,000,000.00 | 1,331,000.00 | 1,331,000.00 | 100.00 |
| 49 | Мэдээллийн технологийн зардал | | | 1,331,000.00 | 1,331,000.00 | 100.00 |
| 53 | Бараа үйлчилгээний бусад за | 180,981,000.00 | 180,981,000.00 | 96,795,100.00 | 96,795,100.00 | 100.00 |
| 54 | Бараа үйлчилгээний бусад за | 180,981,000.00 | 180,981,000.00 | 96,795,100.00 | 96,795,100.00 | 100.00 |
| 97 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭ | 189,981,000.00 | 189,981,000.00 | 104,295,100.00 | 104,295,100.00 | 100.00 |
| 120 | Нэмэлт санхүүжилтийн орлог | 189,981,000.00 | 189,981,000.00 | 104,295,100.00 | 104,295,100.00 | 100.00 |
| 123 | хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих | 9,000,000.00 | 9,000,000.00 | 7,500,000.00 | 7,500,000.00 | 100.00 |
| 124 | захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод | 180,981,000.00 | 180,981,000.00 | 96,795,100.00 | 96,795,100.00 | 100.00 |
| 130 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1.00 | 1.00 | 1.00 | 1.00 | - |
| 133 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 41.00 | 41.00 | 41.00 | 41.00 | 100.00 |
| 134 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | 1.00 | 1.00 | 100.00 |
| 135 | Гүйцэтгэх ажилтан | 33.00 | 33.00 | 33.00 | 33.00 | 100.00 |
| 136 | Үйлчлэх ажилтан | 7.00 | 7.00 | 7.00 | 7.00 | 100.00 |

## 3.Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн шатахууны зардлын анхан шатны баримтын бүрдэл дутуу дээр зөвлөмж хүргүүлсэн.

Аудитыг 2022.01.19-нөөс 2022.01.27–ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2022.01.27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын ахлах аудитор П.Хорлоосүрэн хариуцаж хэрэгжүүлэв.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газарт 2022.01.11-ний өдрийн 20 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

## 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Улсын бүртгэлийн үйл ажиллагааг хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулж хэрэгжүүлэхэд оршино. Улсын бүртгэлийн хэлтэс нь 2021 онд дараах зорилтуудыг хэрэгжүүлж ажилласан байна. Үүнд:1. Улсын бүртгэлийн үйл ажиллагааг цахимжуулж, техник, тоног төхөөрөмж, программ хангамжийг сайжруулна.

2. Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, иргэний, хуулийн этгээдийн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай, чанартай үзүүлнэ.

3. Улсын бүртгэл болон улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтыг сайжруулна.

4. Иргэний, хуулийн этгээдийн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой архивын эх нотлох баримт бичгээр архивын сан хөмрөг бүрдүүлж, баяжилт хийж, түүний хадгалалт хамгаалалтыг сайжруулна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

## 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

## 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын сонгож,

материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 672.9 сая төгрөгөөс 1 хувиар буюу 6.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 4.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

**3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 214.5 сая төгрөгөөр өссөн байна. УБЕГ-аас 171.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө 66.6 сая төгрөгийн бараа материал шилжиж ирсэн. Сонгуулийн зардалтай холбоотой 96.8 сая төгрөгийн санхүүжилт ирж зарцуулсан байна.

**3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн хүрээнд УБЕГ-т 296.0 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зориулан 540.2 сая төгрөгийн төсөв батлагдаж 537.4 сая төгрөгийг улсын төсвөөс авч урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулжээ.

**Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн дансаар 104.3 сая төгрөгийн санхүүжилт авч 96.8 сая төгрөгийг сонгуулийн урсгал зардалд, 7.5 сая төгрөгийг тоног төхөөрөмж худалдан авахад зарцуулсан байна.

**3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санхүүгийн тайлангаарх үндсэн хөрөнгийн тоног төхөөрөмжийн зардал дээр 171.3 сая төгрөгийн хөрөнгийг УБЕГ-аас бэлтгэн нийлүүлсэн зарим үндсэн хөрөнгө зах зээлийн үнэ ханшнаас өндөр үнэтэй нийлүүлэгдсэн байна.

Харин бараа материалын зардал дээр 66.6 сая төгрөгийн зардлаас 32.1 сая төгрөгийн ковидтой холбоотой ариутгал, халдваргүйжилтэй холбоотой бараа материал УБЕГ-аас нийлүүлсэн боловч зарим бараа материалын үнэ зах зээлийн ханшнаас 2 дахин

өндөр үнэтэй нийлүүлэгдсэн байна. Тухайлбал: нэг удаагийн хамгаалах маск 1 ширхэг нь 1800 төгрөг, гар ариутгагч 1 ширхэг нь 20000 төгрөгөөр, тасалгааны агаар ариутгагч 1 ширхэг нь 900000 төгрөгөөр тус тус нийлүүлсэн байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 4 горим сорил гүйцэтгэсэн.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тухайн байгууллага нь Шилэн дансны цахим хуудсанд нийт 150 мэдээлэл байршуулахаас 140 мэдээллийг бүрэн байршуулж,11 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар НДШ-ээ дутуу тайлагнасан 71.9 мянган төгрөгийн албан шаардлага өгөгдөж биелэлтийг 100 хувь хэрэгжүүлсэн байна.

### 3.11 Аудитын үр өгөөжийн тооцоолол

Аудитын явцад түлш халаалтын зардлаас бэлтгэн нийлүүлэгч компанид 532.1 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн байсныг авлагаар тусгаж залруулсан нь санхүүгийн үр өгөөж болсон.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1332.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 532.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 800.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад санхүүгийн тайланд түлш халаалтын зардлаас дулаанаар хангадаг Газрын улаагч ХХК-д 532.1 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн байсныг авлагаар тусгуулж залруулга хийгдсэн.

### 4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. ***Бараа материалын зардалтай холбоотой асуудал***

*1.1. <u>Илрүүлэлт:</u>*

Шатахууны зардлыг зарцуулахдаа нийт 11 шаардах хуудсан дээр хашаа ямар ажлаар явж байгаагаа бичээгүй, даргын гарын үсэг, тамга байхгүй зарцуулсан байна.

*1.2. <u>Өгсөн зөвлөмж:</u>*

Цаашид шатахууны зардлыг зарцуулахдаа дарга, нягтлан бодогчийн хяналтаар баталгаажуулан хаашаа, ямар ажлаар явахаа тодорхой бичиж зарцуулалтад хяналт тавьж ажиллах.

2. ***Шилэн данстай холбоотой асуудал***

*2.1. <u>Илрүүлэлт:</u>*

Тухайн онд шилэн дансны цахим хуудсанд 11 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна.

*2.2. <u>Өгсөн зөвлөмж:</u>*

Шилэн дансны тухай хуульд заасны дагуу мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлж байх.

3. Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 5 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

4. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

(мян төгрөгөөр)

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | Улсын бүртгэлийн хэлтэс | 2 | 1332.1 | 1 | 532.1 | | | | | 1 | 800.0 |

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ө.БАТЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ГАНСҮХ

БЭЛТГЭСЭН: АХЛАХ АУДИТОР П.ХОРЛООСҮРЭН

2022 ОНЫ 02 ДУГААР САРЫН 01-НЫ ӨДӨР